


28. Аймгийн Засаг даргын 2019 оны 11... дүгээр сарын  
-ны өдрийн А/472 дугаар захирамжийн III хавсралт



**"ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА", "ЭРҮҮЛ АЖЛЫН БАЙР"-ЫГ  
ШАЛГАРУУЛАХ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Зорилго:

Эрүүл мэндийг дэмжих байгууллага, Эрүүл ажлын байр болохоор хэрэгжүүлсэн үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд бодитой үнэлгээ өгч шалгаруулах

Удирдлага, зохион байгуулалт

1. Комисс нь "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага", "Эрүүл ажлын байр"-ыг шалгаруулах ажлыг удирдан зохион байгуулахад эрүүл мэнд, хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан хууль, тогтоомж, тушаал шийдвэр болон бусад холбогдох хууль эрхийн актуудыг мөрдлөг болгоно.

2. Комиссын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж, холбогдох байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

3. Комиссын хурлын бэлтгэл ажлыг болон шалгаруулалтанд ирүүлсэн материалуудыг бүртгэх ажлыг комиссын нарийн бичгийн дарга зохион байгуулж ажиллана.

4. Комисс нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор дүгнэлт гаргаж, Эрүүл мэндийг дэмжих байгууллага, Эрүүл ажлын байрыг шалгаруулна.

5. Шалгаруулалтанд ирсэн материалыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/472 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан үнэлгээний шалгуурын дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэхээс гадна, хяналт үнэлгээг тухайн байгууллага дээр хийж, дүнг хурлаар хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ.

6. Комисс нь нэгдүгээр зэргийн гэрчилгээ авснаас хойш нэгээс доошгүй жил ажиллаж амжилтаа бататгасан байгууллага, ажлын байрны шалгаруулалтын материалыг цаасаар болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний төвд хүргүүлнэ.

7. Комиссын нарийн бичгийн дарга нь тухайн орон нутгийн болон улсын хэмжээнд шалгарсан Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, "Эрүүл ажлын байр"-уудын талаар болон газар зүйн байршлын мэдээллийн сан үүсгэж жил бүр мэдээллийг оруулна.

8. Шалгаруулалтад шаардагдах төсөв, шагналын зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусгуулж, шийдвэрлүүлнэ.

"ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА", "ЭРҮҮЛ АЖЛЫН БАЙР"  
ШАЛГАРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Комиссын дарга: - Аймгийн Засаг даргын Нийгмийн асуудал хариуцсан орлогч
- Гишүүд:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
  - Эрүүл мэндийн газрын дарга
  - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн
  - Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга
  - Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн эрүүл ахуй, хяналтын улсын байцаагч
- Нарийн бичгийн дарга: -Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн боловсрол сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

28 Аймгийн Засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын  
ны өдрийн 11/799 дугаар захирамжийн IV хавсралт

**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ  
ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ АНКЕТ**

зураг

1. Овог нэр .....
2. Төрсөн, он, сар, өдөр .....
3. Регистрийн дугаар .....
4. Хүйс .....
5. Төрсөн аймаг, хот, /сум, дүүрэг/ .....
6. Оршин суугаа газрын хаяг .....
6. Боловсрол, мэргэжил .....
7. Ажил эрхлэлтийн байдал:

№	Ажлын газрын нэр	Хугацаа /он/	Эрхэлсэн ажил
1			
2			
3			
4			

8. Ажилласан хугацаа:

Нийт ..... жил, үүнээс: Орхон аймагт ..... жил, тухайн салбарт ..... жил, тухайн хамт олны дотор ..... жил.

9. Шагнагдсан байдал:

№	Шагналын нэр	Хэдэн онд
1		
2		
3		
4		
5		

10. Нэр дэвшиж байгаа шагналын төрөл: .....

11. Шагнуулах үндэслэл: .....

**БАЙГУУЛЛАГЫН ДАРГЫН ГАРЫН ҮСЭГ**